



## МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ХУДАЛДАА АЖ ҮЙЛДВЭРИЙН ТАНХИМ

MONGOLIAN  
CHAMBER OF COMMERCE  
AND  
INDUSTRY



Япон-Монголын бизнесийг дэмжихэд Монголын Үндэсний  
Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын гүйцэтгэх үүрэг

МҮХАҮТ-ын Дарга Т.Дүүрэн

2023.08.18



- 1** МОНГОЛ УЛС, ЯПОН УЛС ХООРОНДЫН ЭДИЙН ЗАСГИЙН ХАРИЛЦААНЫ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ
- 2** МҮХАҮТ-ЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА
- 3** ЭКСПОРТЛОГЧДОД ТУЛГАРЧ БУЙ АСУУДАЛ, ШААРДЛАГАТАЙ ДЭМЖЛЭГ
- 4** ДҮГНЭЛТ



# Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр



МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ХУДАЛДАА АЖ ҮЙЛДВЭРИЙН ТАНХИМ



## ЭЗТХ-ийн ач холбогдол:

Аж үйлдвэрийн салбарын *нэмүү өрт өг шингэсэн экспорт ыг нэмэгдүүлэх*, Японы *өндөр т ехник т ехнологийг нэвт рүүлэх*, валютын орлогыг нэмэгдүүлэх, Японы *т арифын болон т арифын бус саад т от горыг багасгах*, худалдааг хөнгөвчлөх, гаалийн бүрдүүлэлтийг хялбаршуулах гэх мэт боломж бий болно гэж үзсэн байдаг.

## Өмнөх судалгаа:

- Гадаад худалдааны бараа эргэлт 50-60 хувиар нэмэгдэх
- Дотоодын нийт бүтээгдэхүүн 0.33-0.34 хувь өсөх
- Экспорт 0.36 хувь өсөх
- Худалдаа болон хөрөнгө оруулалт нэмэгдэх

Гаалийн тарифын хэлцэл:	<b>5700</b> орчим төрлийн бараа	<b>9300</b> орчим төрлийн бараа

Монгол улс импортын барааны гаалийн тарифын 59% (3429 төрлийн бараа)-ийг, харин Япон улс 86% (8000 төрлийн бараа)-ийг хэлэлцээр хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн тус тус шууд чөлөөлсөн.




# Гадаад худалдаа



### МУ-ын Япон улстай хийсэн худалдаа (2012-2022, сая ам.доллар)



### МУ-ын гадаад худалдаанд Япон улсын эзлэх хувь (2012-2022, %)







# Экспорт, импортын бүтэц



## МУ-аас Япон улсад экспортолсон барааны бүтэц (2022)



## Япон Улсаас импортолсон барааны бүтэц (2022)



2022 онд МУ-ын Япон руу хийсэн экспортод малын өлөн гэдэс **13.4** хувь эзэлсэн бол хөнгөн цагааны экспорт өмнөх жилүүдээс нэмэгдэж **12.4** хувьд хүрсэн байна. Ерөнхийдөө Япон улс руу хийж байгаа экспортын **30-40** хувийг оёмол сүлжмэл, ноос ноолууран бүтээгдэхүүний экспорт эзэлдэг.



МУ-ын импортын **67** хувийг суудлын авто машины импорт эзэлж байгаа бол ачааны автомашин **9.3** хувь, нефтийн бүтээгдэхүүн **3.6** хувийг эзэлж байна.

# Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийн үр дүнд гадаад худалдаанд гарсан өөрчлөлт



Гадаад худалдааны өөрчлөлтийн харьцуулалт (2016-2021)

		2017/2016	2018/2016	2019/2016	2020/2016	2021/2016	2022/2016
Өөрчлөлт (сая ам.доллар)	Экспорт	0.78	12.44	1.49	(4.40)	3.71	1.17
	Импорт	32.54	230.43	254.87	76.10	122.51	343.6
	Нийт	33.33	242.87	256.35	71.70	126.22	344.8
Өөрчлөлт (Хувь)	Экспорт	5.6	88.6	10.6	(31.4)	26.4	8.3
	Импорт	9.8	69.7	77.1	23.0	37.1	103.9
	Нийт	9.7	70.5	74.4	20.8	36.6	100.0


- ЭЗТХ хэрэгжиж эхэлснээс хойш 2 улсын худалдаа жил бүр өссөн бөгөөд 2018 онд огцом өсөж 2016 онтой харьцуулахад экспортын хэмжээ **88.6%**-иар, импортын хэмжээ **69.7%**-иар, худалдааны нийт эргэлт **242.87** сая ам.доллараар өсч **580** сая ам.долларт хүрч байсан.
- 2022 оны хувьд гадаад худалдааны нийт эргэлт болон импортын хэмжээ 2016 оны түвшинээс 2 дахин өсч хоёр улсын гадаад худалдаа **689.4** сая ам.долларт хүрсэн түүхэн амжилтыг үзүүлсэн байна.



# Хөрөнгө оруулалт



## Японы хөрөнгө оруулалт (2012-2022, сая ам.доллар)




- Хөрөнгө оруулалтын хэмжээ 2018 онд хамгийн их хэмжээнд хүрсэн нь ЭЗТХ-ийн үр нөлөө гэж дүгнэж болно.
- 2019-2022 онуудад хөрөнгө оруулалт буурсан нь “Ковид-19” цар тахлын улмаас эдийн засгийн харилцаанд хүндрэл үүсч, хөрөнгө оруулалтын орчин муудсантай холбоотой гэж үзэж байна.



# Хөрөнгө оруулалт



Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй Японы хөрөнгө оруулалттай компанийн тоо



Японы хөрөнгө оруулалт, салбараар



МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ХУДАЛДАА АЖ ҮЙЛДВЭРИЙН ТАНХИМ



- 2020 оны байдлаар Японы хөрөнгө оруулалттай нийт **670** компани Монгол улсад үйл ажиллагаа явуулж байна.
- ЭЗТХ хэрэгжиж эхэлснээс буюу 2016 оноос хойш **100** орчим компани Монгол улсад хөрөнгө оруулсан.



- Япон улсын монгол улс дахь хөрөнгө оруулалт нь **уул уурхайн бус салбарт** төвлөрч байгаа онцлогтой.
- Нийт хөрөнгө оруулалтын **45.3%** нь худалдаа, нийтийн хоолны салбарт орсон бол барилгын салбарт **14.7%** нь орсон байна.

Эх сурвалж: Invest Mongolia сэтгүүл, 2021 оны 5 дугаар сар;





- 1 МОНГОЛ УЛС, ЯПОН УЛС ХООРОНДЫН ЭДИЙН ЗАСГИЙН ХАРИЛЦААНЫ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ
- 2 МҮХАҮТ-ЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА
- 3 ЭКСПОРТЛОГЧДОД ТУЛГАРЧ БУЙ АСУУДАЛ, ШААРДЛАГАТАЙ ДЭМЖЛЭГ
- 4 ДҮГНЭЛТ



# Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн



Танхим өнөөдөр:

Танхим

60+

ЖИЛИЙН  
ТУРШЛАГА

5000+

ГИШҮҮД

21

ОРОН НУТГИЙН  
САЛБАР ТАНХИМ

25

ГАДААД ОРОН  
ДАХЬ  
ТӨЛӨӨЛӨГЧИД

23

БИЗНЕСИЙН  
ЗӨВЛӨЛ

МҮХАҮТ нь Монгол Улсын бизнес эрхлэгчдийг МУ-ын Засгийн газар, төрийн байгууллагууд болон олон улсын байгууллагууд, түншүүд, хөрөнгө оруулагчидтай холбох “ГҮҮР” болж ажилладаг.



## Үндсэн үйлчилгээ:



**ГАРАЛ ҮҮСЛИЙН ГЭРЧИЛГЭЭ**  
болон FORM-D, халал гэрчилгээг олгох




**ХӨНДЛӨНГИЙН ХЯНАЛТ** буюу “ЭКСПЕРТИЗ” хийж  
сертификат олгох



Шинэ бүтээлийн **ПАТЕНТ, БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЗАГВАР,  
БАРААНЫ ТЭМДЭГ, ГАЗАРЗҮЙН ЗААЛТ** буюу оюуны өмчийн  
итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр ажиллах



Байгалийн гаралтай бүтээгдэхүүнд  
“ОРГАНИК БҮТЭЭГДЭХҮҮН” шошго олгох



Байгаль орчинд ээлтэй зочид буудалд  
**НОГООН БУУДАЛ** эко шошго олгох



Гадаад дотоодод төрөл бүрийн  
**ҮЗЭСГЭЛЭН, ЯАРМАГ, БИЗНЕС ФОРУМ**  
зохион байгуулж, эх орноо төлөөлөн оролцох



**АТА КАРНЕЙ** форм олгох




**FORCE MAJOR & HARDSHIP** гэрчилгээ олгох



# МҮХАҮТ-аас олгосон гарал үүслийн гэрчилгээ



Япон улс руу экспортлох бүтээгдэхүүнд олгосон гарал үүслийн гэрчилгээний тоо (2016-2021)



ЭЗТХ хэрэгжиж эхэлснээс хойш Япон улс руу экспортонд гарах бүтээгдэхүүнд олгох гарал үүслийн гэрчилгээний тоо тогтмол нэмэгдсэн бөгөөд 2019 онд хамгийн олон буюу 2016 оноос **98%**-иар өссөн үзүүлэлттэй байсан.

Тогтмол гарал үүслийн гэрчилгээ авдаг бүтээгдэхүүнүүд (Үнийн дүнгээр авч үзвэл Ноолууран бүтээгдэхүүн **80** гаруй хувийг нь эзэлдэг):



Ноолууран бүтээгдэхүүн




Хөнгөн цагаан хайлшийн цутгамал эдийг хүндрүүлэгч



Зэс утас



Хонины өлөн гэдэс



Арьс, ширэн бүтээгдэхүүн



Гүүний хөлдөөсөн ихэс




Ноосон бүтээгдэхүүн




Чацарганы шүүс



Давс



Эсгий бүтээгдэхүүн



Хивс



Чацарганы тос



# МҮХАҮТ-аас зохион байгуулсан арга хэмжээ



МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ХУДАЛДАА АЖ ҮЙЛДЭВЭРИЙН ТАНХИМ



Монгол-Японы Төр, хувийн хэвшлийн X зөвлөлдөх уулзалт 2022 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр зохион байгуулагдсан бөгөөд МҮХАҮТ-аас Монголын улсын 36 аж ахуй нэгжийн төлөөллийн хамтаар оролцсон.



Тус зөвлөлдөх уулзалтын үеэр Японы гадаад худалдааг дэмжих байгууллага(JETRO)-тай хамтран Монгол-Японы бизнес уулзалтыг зохион байгуулсан бөгөөд 2 талын 220 орчим бизнес эрхлэгчид оролцов.




# МУХАҮТ-ын дэргэдэх кластер



МОНГОЛЫН  
САМРЫН КЛАСТЕР

Уул уурхайн бус экспортыг нэмэгдүүлэх, төрөлжүүлэх чиглэлээр Танхимын дэргэд “Монголын Самрын Кластер” ТББ-ыг 2021 онд байгуулсан.




- МУХАҮТ-аас хуш модны самрын экспортыг нэмэгдүүлэх чиглэлээр тууштай ажилласны үр дүнд экспортын хэмжээ 2021-2022 онд 80-90 сая ам.долларт хүрсэн.
- Цаашид 300 сая ам.долларт хүрэх боломжтой




- 1** МОНГОЛ УЛС, ЯПОН УЛС ХООРОНДЫН ЭДИЙН ЗАСГИЙН ХАРИЛЦААНЫ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ
- 2** МҮХАҮТ-ЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА
- 3** ЭКСПОРТЛОГЧДОД ТУЛГАРЧ БУЙ АСУУДАЛ, ШААРДЛАГАТАЙ ДЭМЖЛЭГ
- 4** ДҮГНЭЛТ



## Эдийн засгийн хэлэлцээрийн ашиглалт /ААН-ын тоогоор/



## Нэвтрэхээр төлөвлөж буй зах зээл /хувиар/



- Судалгаанд хамрагдсан гадаад худалдаа эрхлэгч компаниудын 9.8% буюу **109** ААН Япон улсад бүтээгдэхүүн экспортолж, энэхүү хэлэлцээрийн дагуу татварын хөнгөлөлт эдэлсэн гэж хариулсан бол Япон улсаас бараа, бүтээгдэхүүн импортлохдоо татварын хөнгөлөлт эдэлсэн гэж **95** ААН, Япон улстай хамтын ажиллагаа өргөжсөн гэж **144** ААН хариулсан байна.
- Нийт судалгаанд оролцсон ААН-ийн **8.5%** нь Япон улсын зах зээлд нэвтрэхээр төлөвлөж байна гэж хариулжээ.



# “Япон улс руу хийж буй экспортод тулгамдаж буй асуудал” асуумжийн үр дүнгээс:



Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимаас Монгол Улс, Япон Улстай байгуулсан “Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр”-ийн хэрэгжилтийн явцад бизнес эрхлэгчдэд тулгамдаж буй хүндрэлтэй асуудал, цаашид сайжруулах нөхцөлийн талаар тодруулах зорилгоор товч асуулга боловсруулан **50** гаруй аж ахуйн нэгж байгууллагаас авсан.

## Судалгаанд оролцогчдын мэдээлэл:



Экспортлогч

**85%**



Импортлогч

**15%**



**45%**

Нэхмэл сүлжмэл бүтээгдэхүүн үйлдвэрлэгч



**40%**


Хүнс болон гэрийн тэжээмэл амьтны хоол үйлдвэрлэгч



**15%**

Эсгий, арьс ширэн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч

Япон улс руу экспорт хийж хамтран ажилласан хугацаа




Судалгаанд хамрагдсан экспортийн компаниудын **47.5%** нь сүүлийн 3 жилд шинээр экспортын үйл ажиллагаа явуулсан байгааг Япон улстай байгуулсан ЭЗТХ-ийн үр дүнд экспортлогчид нэмэгдсэн гэж үзэж болохоор байна.




# “Экспортод тулгамдаж буй асуудал” асуумжийн үр дүнгээс:



Монгол Улс, Япон улстай байгуулсан  
ЭЗТХ-ийг ашигладаг эсэх талаар



ЭЗТХ-ийн бүтээгдэхүүний гарал  
үүслийн дүрмийг хангаж буй эсэх



Тус хэлэлцээрийн үр өгөөжийг  
нэмэгдүүлэхийн тулд манай улсыг  
зүгээс ямар асуудлуудыг тавьж  
шийдвэрлүүлэх талаар



Судалгаанд хамрагдсан компаниудын **47%** буюу тал орчим хувь нь ЭЗТХ-ийг ашигладаггүй эсвэл мэдэхгүй гэж хариулсан бөгөөд шалтгааныг нь авч үзвэл хүнсний болон эсгий бүтээгдэхүүн үйлдвэрлэгчид ЭЗТХ-ийг мэддэг боловч тарифын хөнгөлөлтөд хамрагдаж чаддаггүй; уул уурхай, арьс шир, хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгчид мэдэхгүй гэж хариулжээ.



# “Экспортод тулгамдаж буй асуудал” асуумжийн үр дүнгээс:



МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ХУДАЛДАА АЖ ҮЙЛДВЭРИЙН ТАНХИМ

### Япон улс руу экспорт хийхэд тулгарч буй хүндрэлтэй асуудлууд



### Япон улс руу экспорт хийхэд болон цаашид экспортыг нэмэгдүүлэхэд шаардлагатай дэмжлэг





- 1** МОНГОЛ УЛС, ЯПОН УЛС ХООРОНДЫН ЭДИЙН ЗАСГИЙН ХАРИЛЦААНЫ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ
- 2** МҮХАҮТ-ЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА
- 3** ЭКСПОРТЛОГЧДОД ТУЛГАРЧ БУЙ АСУУДАЛ, ШААРДЛАГАТАЙ ДЭМЖЛЭГ
- 4** ДҮГНЭЛТ



# Дүгнэлт



- 1 Япон болон Монгол Улсын худалдаа, эдийн засгийн харилцаанд гарсан хамгийн том амжилт бол 2016 онд “**Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр**”-ийг байгуулсан үйл явдал бөгөөд 2 орны гадаад худалдааны эргэлт жил бүр өсөн нэмэгдэж 2022 онд **690** сая ам.долларт хүрсэн байна.
- 2 Хэдийгээр гадаад худалдааны эргэлт өсөн нэмэгдэж байгаа ч энэхүү өсөлт нь Монгол Улсын хувьд зөвхөн **импорт** талдаа байгаа нь цаашид Монгол Улсаас гарах экспортын бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх, төрөлжүүлэх, харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэх шаардлагатайг харуулж байна.
- 3 Монгол Улсын хувьд уул уурхайн бүтээгдэхүүний экспортоос хэт хамаарсан эдийн засагтай бөгөөд цаашид **уул уурхайн бус экспортыг хөгжүүлэх** зорилт тавин ажиллаж байгаа энэ үед Япон улстай байгуулсан ЭЗТХ-ийн хэрэгжилтийг хангах чиглэлд анхаарч ажиллах шаардлагатай байна.
- 4 МҮХАҮТ-аас явуулдаг төрөл бүрийн судалгааны үр дүнгээс харахад МУ-ын аж ахуй нэгжүүдийн хувьд Япон улсын зах зээлд нэвтрэх эрмэлзлэлтэй бөгөөд хамгийн их тулгамдаж буй асуудлуудыг тээвэр логистик болон Япон улсын **өндөр стандарт, шаардлагыг** нэрлэсэн нь байна.
- 5 МҮХАҮТ нь бизнесийн олон талт хамтын ажиллагааг хөгжүүлэх зорилгынхоо хүрээнд төрөл бүрийн арга хэмжээ, бизнес форумыг зохион байгуулдаг бөгөөд цаашид хоёр талын бизнес эрхлэгчдийг холбох, харилцан ашигтай түншлэлийг бий болгох, Япон улсаас Монгол улсад хөрөнгө оруулалт хийх сонирхолтой аж ахуй нэгжүүдэд **найдвартай түнш** олж өгөх гүүр нь болж ажиллана гэдгээ илэрхийлж байна.



# Монгол-Хятад-Японы хамтын ажиллагааны зөвлөл



МУХАҮГ-аас санаачлан “Монгол-Хятад-Японы хамтын ажиллагааны зөвлөл”-ийг байгуулан ажиллахаар төлөвлөн ажиллаж байна.


Тус зөвлөлийг байгуулсанаар Монгол Улсын нөөц, боломжийг Япон Улсын know-how, өндөр технологийг ашиглан Хятад улсын зах зээлд нэвтрэх боломжийг бүрдүүлж цаашлаад Зүүн өмнөд азийн зах зээлд Монгол улсын бараа бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулна.



- Нөөц, түүхий эд
- Экспорт



- Зах зээл
- Үйлдвэрлэл



- Техник, технологи
- Чанар, стандарт

АНХААРАЛ ХАНДУУЛСАНД  
**БАЯРЛАЛАА**



[www.mongolchamber.mn](http://www.mongolchamber.mn)